

## **ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГА ДАХЬ МОНГОЛ УЛСЫН ОРОЛЦОО: ТУРШЛАГА, СУРГАМЖ\***

*Б.Золтуяа\*\**

1. Дэлхийн худалдааны байгууллагын тухай ерөнхий ойлголт
2. ДХБ дахь Монгол Улсын оролцоо
3. ДХБ-ын хүрээнд явагдаж байгаа олон талт худалдааны хэлэлцээ
4. Монгол Улсын үүрэг амлалт
5. Монгол Улсын туршлага
6. Сургамж, дүгнэлт

### **1. Дэлхийн худалдааны байгууллагын тухай ерөнхий ойлголт**

Дэлхийн худалдааны байгууллага /ДХБ/-ыг олон талт худалдааны Уругвайн үе шатны хэлэлцээ /1986-1994/-ний дүнд буюу 1995 онд “ДХБ-ыг байгуулах тухай Марракешийн хэлэлцээр” /цаашид “ДХБ-ын тухай хэлэлцээр”/-ээр байгуулсан.

1947 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр /ТХЕХ буюу ГАТТ/-т үндэслэн байгуулсан энэхүү байгууллагын үндсэн зорилго нь олон улсын худалдааг илүү чөлөөтэй болгох явдал юм. Үүний тулд худалдааны эргэлтийг түргэтгэх, илүү чөлөөтэй болгох, шударга, урьдчилан харах боломжтой болгох зорилт тавьдаг.

ТХЕХ-ээр зөвхөн барааны худалдаанд хамаарах асуудлууд буюу гаалийн тарифыг бууруулах асуудлыг авч үзэж байсан бол ДХБ-ын хүрээнд барааны худалдаанаас гадна үйлчилгээний худалдаа, худалдаанд хамаарах оюуны өмчийн асуудлууд орж байгууллагын хамрах асуудал, үйлчлэх цар хүрээ өргөжсөн. Түүнчлэн дэмпинг, түүний эсрэг авах арга хэмжээ, цахилгаан холбооны үйлчилгээ, маргаан шийдвэрлэх зэрэг бусад асуудал хамрах болсон.

Олон талт худалдааны асуудлаарх шийдвэрийг ДХБ-ын Гишүүд нийтийн тохиролцоогоор гаргадаг.<sup>1</sup> ДХБ-ын шийдвэр гаргах дээд байгууллага нь Гишүүн орнуудын худалдааны асуудал эрхэлсэн сайд нараас бүрдэж буй Сайд нарын бага хурал мөн.<sup>2</sup> Гишүүн тус бүр нэг санал өгөх эрхтэй.<sup>3</sup> Сайд нарын чуулга уулзалт хоёр жил тутам болдог ба чуулга уулзалтын хооронд байнгын ажиллагаатай Ерөнхий зөвлөл шаардлагатай үед хуралдаж шийдвэр гаргадаг.<sup>4</sup> Ерөнхий зөвлөлд Гишүүн орнуудыг төлөөлж ДХБ-ын дэргэд суугаа Байнгын

\* Энэхүү нийтлэл Гадаад харилцааны яам, Засгийн газрын албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.

\*\* Б.Золтуяа - ГХЯ-ны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газар

төлөөлөгчид ордог. Сайд нарын ээлжит 7 дугаар чуулга уулзалт 2009 онд болсон.

Олон талт худалдааг хэлэлцээрүүдээр зохицуулдаг бөгөөд эдгээрийг “олон талт худалдааны хэлэлцээрүүд” гэж нэрлэдэг. Үүнд Барааны худалдааны тухай, Үйлчилгээний худалдааны тухай, Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай хэлэлцээрүүд, түүнчлэн Маргаан шийдвэрлэх асуудлыг зохицуулах дүрэм, журмын тухай харилцан ойлголцох баримт бичиг, Худалдааны бодлогыг хянан үзэх механизм болон Хязгаарлагдмал тооны оролцогчидтой худалдааны хэлэлцээрүүд ордог. Хязгаарлагдмал тооны оролцогчидтой худалдааны хэлэлцээрүүдээс бусад хэлэлцээрийг Гишүүд заавал дагаж мөрдөх учиртай.

Дээрх хэлэлцээрүүд болон тэдгээрийн хэрэгжилтийг эрхлэн зохион байгуулах, хэлэлцээ явуулах, маргаан шийдвэрлэх, техникийн туслалцаа үзүүлэх, олон улсын бусад байгууллагатай хамтран ажиллах зорилгоор Нарийн бичгийн дарга нарын газрыг байгуулсан. Нарийн бичгийн дарга нарын газар Женев хотноо байрлах бөгөөд түүнийг Сайд нарын бага хурлаас томилсон Ерөнхий захирал удирддаг.<sup>5</sup>

ДХБ эдүгээ 153 гишүүнтэйгээс анхдагч 76 Гишүүн байсан бөгөөд 1995 оноос хойш 77 улс Гишүүнээр нэгдэн орсон байна.<sup>6</sup> ОХУ-аас бусад манай улсын худалдааны гол түншүүд бүгд ДХБ-ын Гишүүн болсон бөгөөд БНХАУ 2001 онд Гишүүнээр нэгдэн орсон. ОХУ энэ онд багтан гишүүнээр нэгдэн орох боломжтой гэж ОХУ-ын өндөр албан тушаалтнууд, ДХБ-ын Ерөнхий захирал үзэж байгаагаа мэдээлээд байна.<sup>7</sup>

## **2. ДХБ дахь Монгол Улсын оролцоо**

Монгол Улс ТХЕХ-ийн гишүүнээр элсэх хүсэлтээ анх 1991 онд гаргаж, 6 жил үргэлжилсэн хэлэлцээний үр дүнд буюу 1997 оны 1 дүгээр сарын 29-нд ДХБ-ын гишүүнээр элссэн.<sup>8</sup>

Гишүүнээр элссэнээр манай улс бусад Гишүүн оронтой үндэстний нэн тааламжтай нөхцөл /most-favoured-nation treatment/-өөр<sup>9</sup> худалдаа хийх боломжтой болж, шаардлагатай мэдээллээр чөлөөтэй хангагдах, хоёр талын худалдаанд тулгарч буй асуудалд олон талт механизмыг ашиглах, байгууллагын техникийн туслалцааг авах боломж нээгдсэн.

Манай улс тус байгууллагад гишүүнээр элссэнээс хойш гадаад худалдааны хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр гадаад худалдаатай холбоотой 30 гаруй хуулийг шинээр болон нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шинэчилсэн. Үүний зэрэгцээ үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчдэд худалдаа, бизнес эрхлэх илүү таатай орчин бүрдүүлэх, элдэв шат дамжлагыг цөөрүүлэх арга хэмжээнүүдийг авсан. Үүнд: гаалийн үйлчилгээг хялбаршуулах, худалдаан дахь техникийн саад тотгорыг багасгах, үндэсний стандартыг олон улсын стандартад нийцүүлэх, экспорт, импортын лицензийн тоог цөөлөх, төрийн өмчийн

аж ахуйн нэгжүүд, банк, мал аж ахуй, газар тариалан, харилцаа холбоо, барилгын салбарыг хувьчилж өрсөлдөөнийг дэмжих, зах зээлийг нээлттэй болгох, худалдаа, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх зэрэг арга хэмжээ орж байна.

Өнгөрсөн хугацаанд Монгол Улс ДХБ-ын хүрээнд гишүүнийхээ хувьд оролцож ирсэн. Тухайлбал, Монгол Улсын дараа гишүүнээр элсэж байгаа орнуудтай өөрийн эрх ашгийг хамгаалж хэлэлцээ хийх, мэргэжилтэн сургах зэргээр байгууллагын техникийн хамтын ажиллагааны хүрээнд олонтаа оролцож ирсэн. Монгол Улсын төрийн болон төрийн бус байгууллагуудын мэргэжилтэн сургах, тэдний олон талт худалдааны тогтолцооны талаарх мэдлэг, худалдааны хэлэлцээнд оролцох чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн бүс нутгийн болон үндэсний сургалт-семинаруудыг өөрийн улсад зохион байгуулсан. Үүнд: маргаан шийдвэрлэх, оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудал, стандарт, техникийн зохицуулалт, хорио цээр, хөдөө аж ахуйн хэлэлцээр, үйлчилгээний худалдаа, худалдааны хэлэлцээ явуулах ур чадвар зэргийг дурдаж болно. 2010 оны байдлаар манай мэргэжилтнүүд 150 шахам сургалт, семинар, эдгээртэй төстэй үйл ажиллагаанд оролцжээ.

### **3. ДХБ-ын хүрээнд явагдаж байгаа олон талт худалдааны хэлэлцээ**

1947 оноос хойш Женев, Аннеси, Диллон, Кеннеди, Токио болон Уругвайн гэх зэрэг олон талт худалдааны 8 үе шатны хэлэлцээ хийгдсэн байна.

Олон талт худалдааны хэлэлцээний одоогийн буюу “Доха”-гийн үе шат 2001 онд Катар улсын Доха хотноо эхэлж, хэлэлцээгээр олон улсын худалдааг илүү либералчлахыг зорихын зэрэгцээ “Дохагийн хөгжлийн хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь хөгжиж байгаа болон буурай хөгжилтэй орнуудын олон улсын худалдаан дахь оролцоо, тэдний худалдаанаас хүртэх ашгийг нэмэгдүүлэхэд оршино. Энэ зорилгод хүрэхэд ДХБ-ын бусад Гишүүн орон дэмжих, тэдний олон улсын худалдаанд оролцох чадавхийг бэхжүүлэхэд ихээхэн анхаарч, техникийн туслалцаа үзүүлж байдаг. Хэлэлцээ нь манай улсын оролцож байгаа анхны олон талт хэлэлцээ юм.

Дохагийн хэлэлцээг анх 2003 онд дуусгах зорилт тавьж байсан боловч өнөөг хүртэл амжилттай болоогүй байна. Энэ нь хөгжингүй болон хөгжиж байгаа Гишүүн орнууд тохиролцоонд хүрч чадахгүй байгаатай холбоотой. Тохиролцоонд хүрч чадахгүй байгаа асуудалд хөдөө аж ахуй, хөдөө аж ахуйн бус бараа болон үйлчилгээний худалдаа голлож байна.

Хэлэлцээнд манай улсын ашиг сонирхол төвлөрч байгаа асуудалд хөдөө аж ахуй болон хөдөө аж ахуйн бус бараа,

бүтээгдэхүүний зах зээлд нэвтрэх, худалдааг хөнгөвчлөх, үйлчилгээний худалдаа орж байна. Эдгээр хэлэлцээний хүрээнд манай улс хөгжиж байгаа орнууд, жижиг, эмзэг эдийн засагтай орнууд, далайд гарцгүй хөгжиж байгаа орнууд, сүүлд нэгдсэн Гишүүн орнуудтай хамтран байр сууриа илэрхийлэн оролцож байгаа юм.

Худалдааг хөнгөвчлөх асуудал нь дамжин өнгөрөх тээвэртэй холбоотой тул манайх энэ хэлэлцээнд өөрийн орны байр суурийг илэрхийлэн хэд хэдэн саналыг бусад гишүүн оронтой хамтран гаргасан.

Манай улс жижиг, эмзэг эдийн засагтай орны хувьд хэлэлцээнд ийм Гишүүн орнуудын ашиг сонирхолыг хамгаалан оролцож, тусгай болон ялгавартай /special and differential treatment/ нөхцлүүдийг хэлэлцээний бүх асуудалд тусгуулах чиглэлд ажиллаж байна. Тусгай болон ялгавартай нөхцөл нь буурай орнууд одоогийн хэлэлцээгээр нэмэлт үүрэг амлалт авахгүй байх, хөнгөлөлттэй нөхцлөөр үүрэг амлалт авах, нэмэлт буулт хийхгүй, эсвэл бага буулт хийх явдал юм.

Сүүлд нэгдэн орсон Гишүүн орнуудын бүлэгт манай улс хамрагдан үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ бүлэгт 1995 оноос хойш элссэн 14 гишүүн орон нэгдэж, элсэх үедээ өргөн хүрээний үүрэг, амлалтуудыг авсан тул ялгавартай нөхцөл авах байр суурьтай байна. Хэлэлцээний явцад манай улсыг сүүлд нэгдэн орсон гишүүн орноор хүлээн зөвшөөрсөн нь манай улсын хувьд цаашид тариф бууруулахгүй байх ач холбогдолтой юм.

Үйлчилгээний худалдаанд хамаарах хэлэлцээгээр Гишүүн орнууд өөрсдийн зах зээлийг илүү нээлттэй болгох талаар санал, хүсэлт гаргаж тохиролцох ёстой. Одоогийн байдлаар, манай улс өөрийн орны саналыг бэлтгэсэн бөгөөд бусад Гишүүн орноос зах зээлээ нээлттэй болгох хүсэлтийг хүргүүлээд байна.

#### **4. Монгол Улсын үүрэг амлалт**

Монгол Улс ДХБ-ын гишүүний хувьд өөрийн худалдааны бодлогоо олон талт худалдааны дүрэм, журамд нийцүүлэн боловсронгуй болгох үүрэг амлалт авсан. Үүнд: барааны болон үйлчилгээний худалдаанд хамаарах үүрэг амлалт, түүнчлэн импортын татвар хураамж, тарифын бус арга хэмжээ, экспортын арга хэмжээ, урамшуулал болон үйлдвэрийн бодлого, хувьчлалын хөтөлбөр, хөрөнгө оруулалт, гаалийн журам зэрэг нийт 20 гаруй үүрэг амлалт орсон.<sup>10</sup>

##### **Барааны худалдаа**

Манай улс импортын бараанд ногдуулах гаалийн тарифын хэмжээ, тарифын дээд хязгаарыг Гишүүн орнуудтай тохирсоны үндсэн дээр тогтоосон. Гаалийн тарифын дээд хязгаарын дундаж 18 хувь байхаар тогтсон. Харин одоо мөрдөж байгаа тарифын хэмжээ ихэнх бараанд 5 хувь байгаа бөгөөд үүнийг манай бодлого боловсруулагчид

аливаа барааны тарифыг амлалтын дээд хязгаар хүртэл нэмэгдүүлэх боломжтой. Энэхүү “орон зай”-г ДХБ-ын зүгээс худалдааны бодлогын ил тод байдалд сөргөөр нөлөөлөхүйц хэмээн үздэг боловч хөгжиж байгаа болон буурай хөгжилтэй орнуудын хувьд энэ нь хялбар бөгөөд зардал багатай “хамгаалалт”-ын арга хэмжээ болж чаддаг талтай юм.

#### Үйлчилгээний худалдаа

Үйлчилгээний салбарт манай улс тодорхой үүрэг амлалтууд авсан. Үйлчилгээний худалдаанд хамаарах салбарт банк, санхүү, даатгал, аялал жуулчлал, бизнесийн үйлчилгээ, харилцаа холбоо, барилга, тээвэр, боловсрол, эрүүл мэнд зэрэг хамаарах бөгөөд эдгээр салбарын зах зээлд нэвтрэх болон үндэсний нөхцлийн хувьд манай улс хувь этгээдийн оролцооны хэлбэрээр үзүүлэх үйлчилгээнээс бусад хэлбэрийг нээлттэй болгох үүрэг амлалт авсан.<sup>11</sup> Үүрэг амлалтын дагуу манай үйлчилгээний салбар харьцангуй нээлттэй болсон.

Монгол Улсын ДХБ-д нэгдэж орох үе буюу 1990-ээд он, саяхныг хүртэл манай олон нийт, тэр дундаа хувийн хэвшлийнхэний “үйлчилгээний худалдаа”-ны талаарх ойлголт хангалтгүй байжээ. Үйлчилгээнд гол төлөв зочид буудал, нийтийн хоол зэргийг хамруулж ойлгодог байсан. Олон талт худалдаан дахь “үйлчилгээний худалдаа” харьцангуй шинэ ойлголт юм.

Хэдийгээр нилээн нээлттэй үүрэг амлалт авсан ч ДХБ-д нэгдэж орох үед их хувьчлал өрнөж, “хувийн хэвшил” гэдэг ойлголт болон хувийн хэвшил шинэ тутам үүсэн бий болж байсан учраас төрийг хэрэгцээтэй мэдээллээр хангах, дэмжих, зөвлөлдөх хэвшил төдийлөн бүрэлдэн бий болж чадаагүй, харин ч тухайн үеийн хөгжлийн явц нээлттэй бодлогын үр дүнд үүрэг амлалтаас ч давсан, зах зээлийн илүү нээлттэй харилцаанд шилжсэн.

Салбарыг нээлттэй болгох үүрэг амлалтыг хоёр талаас нь тайлбарлаж болно. Нэг талаас, энэхүү нээлттэй үүрэг амлалт нь шилжилтийн дараах үед үйлчилгээний салбарыг хөгжүүлэх суурийг тавихад чухал ач холбогдолтой байсан гэж дүгнэж болно. ДХБ-ын дүрэм, журамтай нийцсэн зарчим эхнээсээ үйлчилж, салбарыг дэлхийн зах зээлд өрсөлдөж чадахуйц түвшинд хүргэнэ. Нөгөө талаас, дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээ өсөн нэмэгдэхийн хэрээр өөрсдийгөө хамгаалах тэдний сонирхол нэмэгдэж, нээлттэй үүрэг амлалтыг шүүмжлэх явдал гарч болзошгүй юм. Үүнийг зөвхөн ДХБ-тай холбож үзэх бус, харин тухайн шилжилтийн үед үүссэн гарцаагүй нөхцөл байдалтай уялдуулж дүгнэх нь зүйтэй санагдана.

#### Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбоотой асуудлууд

Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбоотой асуудлаар манай улс ТРИПС буюу Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбоотой асуудлын тухай хэлэлцээрийг шилжилтийн үегүйгээр бүрэн дүүрэн хэрэгжүүлэх үүрэг амлалт авсан. Эрх зүйн хувьд манай оюуны өмчид

хамаарах хуулиуд хэлэлцээрт нийцсэн боловч хэлэлцээрийн хэрэгжилт, ялангуяа хилийн үйл ажиллагаанд хэлэлцээрийн шаардлагыг хэрэгжүүлэх, сайжруулахад дорвитой арга хэмжээ авах нь зүйтэй гэж дүгнэж байна.

#### Маргаан шийдвэрлэх асуудал

Худалдаатай холбоотой маргаан шийдвэрлэх асуудал буюу Маргаан шийдвэрлэх асуудлыг зохицуулах дүрэм, журмын тухай харилцан ойлголцох баримт бичиг нь олон талт худалдааны тогтолцооны суурь баримт бичгийн нэг юм. ДХБ-ын хүрээнд Маргаан шийдвэрлэх байгууллагыг байгуулснаар ТХЕХ-тэй харьцуулбал илүү боловсронгуй, нарийн тогтолцоотой болсон. ДХБ байгуулагдсанаас хойшх хугацаанд Маргаан шийдвэрлэх байгууллагаар орсон маргааны тоо ТХЕХ-ийн түүхэнд шийдвэрлэгдсэн маргааны тооноос 4 дахин их байна. Харин манай улс ДХБ-д нэгдэж орсноос хойшх хугацаанд аливаа маргаанд нэхэмжлэгч, хариуцагч, эсвэл гуравдагч тал болон оролцож байгаагүй.

#### Үүрэг амлалтын хэрэгжилт

Ерөнхий байдлаар авч үзэхэд манай улс ДХБ-д нэгдэж ороходоо авсан үүрэг амлалтаа биелүүлж байна. Үүнийг Гишүүн орнууд манай улсын худалдааны бодлогыг анх удаа 2005 онд хянахдаа сайшаан дүгнэсэн. Тодруулбал, манай Засгийн газраас хэрэгжүүлж буй нээлттэй эдийн засаг, чөлөөт худалдааг эрхэмлэн, түүнийгээ бодлогодоо тусган хэрэгжүүлж байгааг сайшаан дэмжээд, худалдааны бодлогодоо анхаарвал зохих асуудлаар зөвлөмж гаргасан. Гишүүн орнууд манай зах зээлийн баримжаатай өөрчлөлт шинэчлэлтийг үргэлжлүүлэх, үйлчилгээний худалдаанд өрсөлдөөнийг дэмжиж, либералчлах, хууль бус худалдааг хязгаарлах үүднээс экспортын татварыг халах, онцгой албан татварыг үндэсний нөхцлөөр ногдуулах, гадаадын хөрөнгө оруулалтад олгож буй хөнгөлөлтийг халах, стандарт, техникийн зохицуулалтыг олон улсын шаардлагад нийцүүлэх ажлыг үргэлжлүүлэх, илүү ил тод болгох, засгийн газрын худалдан авах үйл ажиллагааг илүү нээлттэй болгох зэрэг зөвлөмжүүдийг гаргасан.

Олон талт худалдааны хэлэлцээрүүд болон үүрэг амлалтын хэрэгжилтийг хангах нь урт удаан хугацааны амаргүй үйл явц байсан. Энэ үйл явцад хандивлагч байгууллага, улс орнуудын дэмжлэгийг Засгийн газрын зүгээс авсан. Жишээ нь: Германы техникийн хамтын ажиллагааны агентлаг /GTZ/, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, түүнчлэн НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр дэмжлэг үзүүлсэнийг тэмдэглэх нь зүйтэй.

ДХБ-ын үйл ажиллагаа, олон талт хэлэлцээнд баримтлах Монгол Улсын байр суурь, удирдамжийг боловсруулах, Монгол Улсын эрх ашгийн тусгалыг хангахад чиглэсэн хэлэлцээ хийхэд дэмжлэг үзүүлэх Засгийн газрын ажлын хэсгийг Үйлдвэр, худалдааны сайд /хуучнаар/-аар ахлуулан 2004 онд, Гадаад харилцааны сайдаар ахлуулан 2010 онд шинэчлэн ажиллаж байна.

Түүнчлэн хэлэлцээрүүдийн хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын төрөөс гадаад худалдааны талаар баримтлах бодлого, Худалдааны тухай, Гадаад худалдааны хамгаалалтын арга хэмжээний тухай хуулийн төслийг боловсруулж байна.

## **5. Монгол Улсын туршлага**

### Боловсруулаагүй ноолуурын экспортын татвар

Монгол Улс ДХБ-д нэгдэн орохдоо боловсруулаагүй ноолуурын экспортын татварыг элссэнээс хойш 10 жилийн турш буюу 2007 он хүртэл үе шаттайгаар халах үүрэг амлалт авсан боловч дотоодын ноолуур боловсруулах үйлдвэрүүдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд экспортын татварыг хадгалж үлдэх шаардлага байсныг харгалзан үүрэг амлалтын хэрэгжилтийн хугацааг сунгуулсан. Өөрөөр хэлбэл боловсруулаагүй ноолуурт ногдуулж байсан экспортын татварыг 2012 он хүртэл хэрэгжүүлэх боломжтой болсон.<sup>12</sup> Ийнхүү сунгуулсан нь Гишүүн орнууд, ялангуяа худалдааны ашиг сонирхол нь хөндөгдөх БНХАУ, түүнчлэн манай улсын худалдааны томоохон түнш болох Европын Холбоо, АНУ, Канад, Энэтхэг, БНСУ, Япон зэрэг Гишүүн орнуудтай хэлэлцээ хийж, эдгээр орны дэмжлэгийг авч чадсан явдал юм. Энэхүү туршлага олон талт худалдааны тогтолцоо, түүний хэлэлцээрүүдийг өөрийн орны ашиг сонирхолд нийцүүлэн ашигласан анхны туршлага болсон.

Дээрх шийдэл нь дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих, түүхий эдээр хангах зорилготой байв. Аливаа худалдааны бодлогын сонголт нэг бүлэгт ашигтай тусах боловч нөгөө бүлэгт алдагдалтай тусдаг. Экспортын татварыг малчид халааснаасаа төлж байгаа боловч хэрэгжүүлж чадсан тохиолдолд дотоодын ноолуур үйлдвэрлэгчдэд тодорхой хэмжээний дэмжлэг болж чадна. Гэтэл экспортын татвартай барааг хууль бусаар хил давуулах явдал ихээхэн гардаг тул татварыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хууль бус худалдаа зэрэг сөрөг үзэгдэлтэй тууштай тэмцэх хэрэгтэй юм. Харин урт хугацаанд зах зээлд өрсөлдөх чадвартай салбар, бараа, бүтээгдэхүүн шалгарч үлдэнэ.

Өнөөдөр манай гадаад худалдааг зангидсан нэгдмэл бодлого үгүйлэгдэж байна. Ийм бодлого, ерөнхий чиглэл байхгүйгээс салбар бүр өөрсдийн дураар аливаа арга хэмжээ авч байна. Нөгөөтэйгүүр, гадаад худалдааны арга хэмжээ өнөөгийн байдлаар эдийн засгийн тооцоонд үндэслэх бус, харин улс төрийн ашиг сонирхолд дулдуйдах нь элбэг болсон. Үүнийг харуулж байгаа тод жишээ бол ноолуурын татварыг Ерөнхийлөгчийн 2009 оны сонгуулийн үеэр цуцалсан явдал юм.

### Импортын шар айрагт ногдуулж байсан онцгой албан татвар

Улсын Их Хурал 2004 оны 12 дугаар сарын 2-ны өдөр “Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийг баталж, дотоодын литр пивонд 0.20 ам.доллар, импортын литр

шар айрагт 0.50 ам.долларын онцгой албан татвар ногдуулжээ. Ийнхүү ялгаатай тогтоосон нь ТХЕХ-ийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг буюу ДХБ-ын тулгуур зарчим болох “үндэсний нөхцөл” /national treatment/ -ийг зөрчсөн арга хэмжээ байв.

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, 10.3-т “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”, түүнчлэн Үндсэн хуулийн хавсралт хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуульд харшлаагүй Монгол Улсын олон улсын гэрээ бусад хуулийн заалттай зөрчилдсөн тохиолдолд мөнхүү олон улсын гэрээний заалтыг баримтална” гэж заасныг тус тус зөрчсөн үндэслэлээр иргэн М.Түмэн-Өлзий нар Үндсэн Хуулийн Цэцэд өргөдөл гаргасан байв. Цэцийн 2005 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 2/03 дугаар дүгнэлтээр онцгой албан татварын хэмжээг тэгшитгэсэн. Монгол Улсын Их Хурлаас 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдөр баталсан “Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-иар импортын пивонд ногдуулах онцгой албан татварын хэмжээг дотоодын үйлдвэрийн пивонд ногдуулж байсан хэмжээнээс мөн ялгавартай тогтоосныг Үндсэн Хуулийн Цэцийн 2009 оны 2 дугаар тогтоолоор 2005 оны дүгнэлтийг үндэслэл болгон дахин тэгшитгэж литр пивонд 0.20 ам.доллар болгосон.

## **6. Сургамж, дүгнэлт**

Дээрх туршлагаас зарим дүгнэлтийг хийж болно. Манай улсын ДХБ-д нэгдэж орох, түүнчлэн нэгдэж орсны дараахан үед зах зээлийн эдийн засгийн шинэ тогтолцоонд үүсэн бий болж байсан хувийн хэвшил, дотоодын үйлдвэрүүдийн ДХБ, олон талт худалдааны тогтолцооны талаарх мэдээлэл хомс, үүнээс улбаалан энэ талаарх мэдлэг төдийлөн сайн байсангүй.<sup>13</sup> Харин өнөөдөр байдал өөрчлөгдөж байгаа бөгөөд дотоодын үйлдвэрүүд, хувийн хэвшлийнхэн ДХБ-ын талаар тодорхой хэмжээний ойлголт, мэдлэгтэй болсон хэдий ч тэр нь учир дутагдалтай байна. ДХБ-ын хэлэлцээрүүдээр хориглосон зүйлсийг нь мэдэх боловч хэлэлцээрүүдээр нээлттэй олгож байгаа боломжуудыг төдийлөн харахгүй байна гэж дүгнэж болох юм. Тиймээс ДХБ, манай улсын нэгдэж орохдоо авсан үүрэг амлалтыг шүүмжлэхийн сацуу тэдгээр боломжуудыг хэрхэн ашиглаж болох талаар Засгийн газарт санал оруулж, илүүтэй хамтран ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

Дээр дурдсан “боломж”-уудыг ашиглахад Засгийн газар төдийгүй хувийн хэвшилд шаардлагатай мэдлэг, мэдээллийн бүтэц, тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай нь харагдаж байна. Нэг талаас хувийн хэвшил нь Засгийн газраа хэрэгцээтэй мэдээллээр хангах, нөгөө талаас Засгийн газар нь ДХБ-ын хэлэлцээрүүдийг үр ашигтай ашиглах тогтолцоо



үгүйлэгдэж байна. Жишээ нь, гадаад худалдааны хамгаалалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүтэц, тогтолцоо байхгүй, гадаад худалдааны асуудал хариуцсан газарт энэ чиглэлийн мэдлэг, мэдээллийн сан бүрдэж чадаагүй бөгөөд тэрхүү мэдлэг, мэдээллийг түгээх боломж, чадамж нь хязгаарлагдмал байгааг өөрчилж, худалдааны асуудал хариуцсан газрын тогтвортой үйл ажиллагаа, бодлогын залгамж чанарыг алдагдуулахгүй байхад анхаарах хэрэгтэй юм.

ДХБ-ын “тоглоомын дүрэм”-ээр тоглохын тулд улс төрийн хүсэл зориг, ДХБ-ын хэлэлцээрүүд, тэдгээрээс гарах үр дагаврын талаарх бүрэн ойлголт, тооцоо, судалгаа, түүнчлэн дүрэм, журмыг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх тогтолцоо шаардлагатай байгааг өнгөрсөн хугацаа харуулж байна.

### ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. ДХБ-ын тухай хэлэлцээрийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг.
2. ДХБ-ын тухай хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг.
3. ДХБ-ын тухай хэлэлцээрийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг.
4. ДХБ-ын тухай хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дахь хэсгүүд.
5. Ерөнхий захирлаар Франц улсын иргэн Паскаль Лами 2005 оноос хойш ажиллаж байна.
6. ДХБ-ын тухай хэлэлцээрийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасны дагуу ДХБ-д улс орон, түүнчлэн гаалийн тусгай нутаг дэвсгэр гишүүнээр нэгдэж орох боломжтой. Жишээ нь: Тайвань, Макао, Хонгконг ДХБ-ын Гишүүд мөн.
7. [www.wto.org](http://www.wto.org)
8. Манай худалдааны түнш БНХАУ 15 жилийн турш хэлэлцээ хийсэн бол ОХУ-ын ДХБ-ын гишүүн болох хэлэлцээ 18 дахь жилдээ үргэлжилж байна.
9. ТХЕХ-ийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг.
10. “Монгол Улс нэгдэн орох асуудлаарх ажлын хэсгийн илтгэл”, ДХБ-ын WT/ACC/MNG/9 дугаар бүхий баримт бичиг.
11. ДХБ-ын WT/ACC/MNG/9 Add.2 дугаар бүхий баримт бичиг. Үйлчилгээний худалдааны тухай хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт заасны дагуу үйлчилгээ үзүүлэх 4 хэлбэрийг тодорхойлсоныг үзнэ үү.
12. ДХБ-ын Ерөнхий зөвлөлийн 2007 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн шийдвэр, WT/L/695 дугаар баримт бичиг.
13. Д.Цогтбаатар “Mongolia’s WTO Accession: Expectations and Realities of WTO Membership”, [http://www.wto.org/english/thewto\\_e/countries\\_e/mongolia\\_e.htm](http://www.wto.org/english/thewto_e/countries_e/mongolia_e.htm) хаягаас авах боломжтой.